

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 07-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2023 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 07-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 06 дугаар сарын 07-ны өдөр, Лхагва гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-2
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	3-18

- 1.Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2023.05.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/ 3-18
- 2.Байнгын хорооны тогтоолын төсөл /Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 06 дугаар сард Инновац, цахим бодлогын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/ 18

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 07-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
Инновац, цахим бодлогын байнгын хорооны 06 дугаар сарын 07-ны
өдөр /Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Инновац, цахим бодлогын байнгын хорооны дарга Э.Батшугар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 11 гишүүнээс 6 гишүүн хүрэлцэн ирж, 54.5 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 12 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Э.Бат-Амгалан, Х.Ганхуяг;

Эмнэлгийн чөлөөтэй: Ц.Сэргэлэн.

Нэг.Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2023.05.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын зөвлөх С.Тэнгис, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Цахим хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Билэгдэмбэрэл, мөн яамны Харилцаа холбооны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Л.Энхбат, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын шинжээч Ж.Амгалан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Л.Батмөнх, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Х.Энэбиш, Инновац, цахим бодлогын байнгын хороо хариуцсан референт П.Болорцэцэг нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Саранчимэг, Ц.Идэрбат, Ч.Ундрэм, Н.Ганибал, Э.Батшугар нарын тавьсан асуултад Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын зөвлөх С.Тэнгис нар хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооны дарга Э.Батшугар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн нар үг хэлэв.

Э.Батшугар: Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 07-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 0
Бүгд: 8
100 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 07 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл /Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 06 дугаар сард Инновац, цахим бодлогын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Х.Энэбиш, Инновац, цахим бодлогын байнгын хороо хариуцсан референт П.Болорцэцэг нар байлцав.

Төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Э.Батшугар: “Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 06 дугаар сард Инновац, цахим бодлогын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 0
Бүгд: 8
100 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 56 минут үргэлжилж, 11 гишүүнээс 8 гишүүн хүрэлцэн ирж, 72.7 хувийн ирцтэйгээр 12 цаг 08 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Э.БАТШУГАР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 07-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 06 дугаар сарын 07-ны өдөр,
Лхагва гараг Төрийн ордон
“Их эзэн Чингис хаан” танхим
11 цаг 12 минут.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2023
ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ 06 ДУГААР
САРЫН 07-НЫ ӨДӨР /ЛХАГВА
ГАРАГ/-ИЙН ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Э.Батиугар: Байнгын хорооны 2023 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 11.6-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя.

Батиугар 28 дугаар тойрог, Идэрбат 18 дугаар тойрог, Саранчимэг 22 дугаар тойрог, Ундрам 13 дугаар тойрог, Учрал 28 дугаар тойрог, Чинбүрэн 23 дугаар тойрог.

Байнгын хорооны хуралдааны ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдааны хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 2 асуудал байгаа.

Эхний асуудал нь Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, ЭМД-ын тухай хуульд нэмэлт оруулах тухай болон бусад хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд. Засгийн газраас 2023 оны 05 дугаар сарын 29-ний өдөр өргөн мэдүүлсэн.

2 дугаар асуудал нь “Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 06 дугаар сард Инновац цахим бодлогын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хороонд хорооны тогтоолын төсөл.

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүд байна уу? Алга байна.

Хэлэлцэх асуудалдаа оръё. 1 дүгээр асуудал руугаа шууд оръё.

Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай болон бусад хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх талаар хэлэлцүүлгийг явуулъя.

Төсөл санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Ням-Осорын Учрал танилцуулна.

Н.Учрал: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.1-д цахим хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлт, удирдлагаар хангаж, төрийн үйлчилгээг шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлж, иргэдийг цаг хугацаа, зардлыг хэмнэнэ гэж, 4.1.1-д төрийн байгууллагын мэдээллийг иргэн, ААН-ээс шаарддаг байдлыг халж, иргэд 1 удаа бүртгүүлээд төрийн цахим үйлчилгээг шуурхай авдаг болох зорилтыг бүрэн хэрэгжүүлж, төрийн цахим үйлчилгээг нэгдсэн стандартад оруулна гэж, 4.4.11-д Монгол Улсын Үндсэн хуульд заасан иргэний мэдээлэл авах эрхээ

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 07-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

хэрэгжүүлэх хууль, эрх зүйн орчныг сайжруулах зорилтыг дэвшүүлсэн.

Мөн Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 5.3 дахь заалтын 1 дүгээр үе шат 2021-2030 он, 4-т төрийн байгууллагын хоорондын болон төр, иргэний нийгэм, бизнесийн байгууллагуудын мэдээллийн солилцоо сайжирч, захиргааны зардал бууран үйлчилгээний үр дүн сайжирна гэж, 5-д төрийн байгууллагын шийдвэр гаргах үйл явцад иргэд олон нийтийн саналыг цахимаар авах нөхцөлийг бүрдүүлж мэдээллийн ил тод байдал нэмэгдэнэ гэж, 9.4 дэх заалтын 1 дүгээр үе шатад мэдээллийг цахимжуулж иргэдэд төрийн үйлчилгээг цахимаар хүргэх тогтолцоог бий болгоно гэж тус тус заасан.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд Монгол Улсын Их Хурлаас 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийг хэлэлцэн баталж, 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөж эхэлсэн бөгөөд уг хуулиар хүн, хуулийн этгээд, төрийн байгууллагад цуглуулж, боловсруулж, ашиглаж байгаа мэдээлэлд түргэн шуурхай хандах, мэдээлэл эрэх хайх, олж авах нөхцөлийг бүрдүүлэх, хүн, хуулийн этгээдэд мэдээлэл, үйлчилгээг цахим орчны дэд бүтэц, техник, технологийн суурь, дунд нөөцөд тулгуурлан цахим хэлбэрээр хүргэх, дамжуулах, цахим баримт бичгийг хүлээн зөвшөөрөхтэй холбоотой харилцааг зохицуулж байна.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсэгт цаасан болон хуульд заасны дагуу цахим хэлбэрээр гаргасан хүсэлтийг бичгээр гаргасан хүсэлт гэж үзнэ гэж, 30 дугаар зүйлийн 30.5 дахь хэсэгт хуульд өөрөөр заагаагүй бол цахим баримт бичиг нь цаасан баримт бичигтэй нэгэн адил хүчинтэй байна гэж тус тус

зааж, цахим баримт бичгийн эрх зүйн хүчин чадлыг сайжруулж, иргэний мэдээлэл авах эрхийг бэхжүүлсэн.

Мөн Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр баталсан Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд цахим болон цаасан баримт бичгийг үйлдэх, илгээх, хүлээн авах талаарх зохицуулалтуудыг тусгаж, цахим үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхой хэмжээгээр бүрдүүлсэн боловч асуудал бэрхшээл тулгарсаар байна.

Энэхүү цахимаар харилцах нөхцөлийг бусад салбарын хуулиудад адилтган тусгаж хүлээн зөвшөөрөх замаар хууль хоорондын нийцлийг хангаж, практикт үүсээд байгаа зөрөөтэй ойлголтыг арилгах зайлигүй хэрэгцээ шаардлага нэгэнт үүсжээ. Хэдийгээр цахим хэлбэрээр харилцах, цахим баримт бичиг үйлдэж болох тухай Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд тусгасан боловч цахим баримт бичгийн хувь нь цаасан хувьтай адил хүчинтэй байхаар заасан боловч цаасан болон цахим хувь хоорондоо зөрсөн тохиолдолд цаасан хувийг баримтлахаар заасан зэргээс хамаарч, байгууллагууд цахимд шилжсэн ч цаасан хэлбэрийг давхар хадгалдаг. Бодит байдал дээр цахим шилжилт нь хурдасгуур биш давхар ачаалал бий болгож байгаа тохиолдлууд гарсаар байна. Өөрөөр хэлбэл Монгол Улсын Их Хурлаас баталсан цахим хөгжлийг дэмжсэн багц хуулиудын хүрээнд буюу Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд заасан бичгээр гэсэн нэр томъёоны агуулгад цаасан эсхүл цахим хэлбэрийн аль алиныг хамааруулж ойлгохоор заагаад харин бусад салбарын хуульд бичгээр гэсэн агуулгад зөвхөн цаасан хэлбэрийг тооцож ойлгож байгаа нь тухайн хуульд заасан мэдээлэл солилцоо, үйлчилгээг цахим хэлбэрээр давхар хүргэхэд хууль хоорондын нэр томъёоны зөрөөтэй байдлыг үүсгэж, Монгол Улсын үндэсний цахим шилжилтийг удаашруулах, үл ойлголцох

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 07-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

нөхцөл байдалд хүргэж байгааг шийдвэрлэх цаг нь болжээ.

Иймд Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.24 дэх заалтад хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор хэд хэдэн хуульд нэгэн зэрэг өөрчлөлт оруулахаар хуулийн төсөл боловсруулна гэж, мөн хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэгт хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор хэд хэдэн хуульд нэгэн зэрэг өөрчлөлт оруулах хуулийн төслийг Засгийн газар санаачлан боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлж болно. Энэ тохиолдолд өөрчлөлт оруулж байгаа хууль тус бүрд үзэл баримтлалыг тодорхойлох шаардлагагүй гэж тус тус заасны дагуу холбогдох хуулийн төслүүдийг боловсруулж, тус хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт заасан аргачлалыг баримтлаагүй болно.

Төрийн хууль тогтоомж нэг нь нөгөөдөө гох дэгээ, чагт зангилаа болсон цаасан хэрэм саад босгосныг засаж залруулж, тайлж чөлөөлөхийн эрхэм дээд зорилго нь ардчилсан төрийн уг эх булаг болсон ард иргэддээ хөнгөн шуурхай үйлчлэх, үр ашиггүй зардал чирэгдлийг эрс бууруулах, авлигын хөрс болсон хүнд суртлын ханыг нураахад оршиж байна. Энэ бол чөлөөлөлт юм.

Иргэний эдийн засаг, нийгэм соёлын үндсэн эрхээ эдлэх замыг нээн чөлөөлөх эрхэм үнэт зүйл, үзэл санаа өөртөө шингээн агуулсан өөрчлөлтийн салиггүй нэг чухал хэсэг юм. Хууль тогтоогч та бүхнийг төрөө цаасан хүнд суртлаас чөлөөлж, цахим хөнгөн сурталд тууштай шилжих, цаасан суурьтай хуулийн гох дэгийг тайлахын төлөө идэвхтэй ажиллана гэдэгт итгэж байна.

Улсын хөгжлийн чөдөр тушаа, хүний амьдралын чанарт саад тээг болсон авлига, хээл хахуулийн хөрс суурь болсон хүнд суртлыг эрс багасган, хуулийн давхардал хийдлийг арилгахад

бодлого шийдлээ уралдуулж өгөхийг хүсье.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, хуулийн төслийг хэлэлцэн дэмжиж өгөхийг хүсье.

Э.Батшугар: Учрал сайд аа, баярлалаа.

Одоо хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Ням-Осорын Учрал Цахим хөгжил, харилцаа холбооны сайд, Сүхээгийн Тэнгис Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын зөвлөх, Бадамдоржийн Билигдэмбэрэл Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Цахим хөгжлийн бодлогын хэрэгжилтийн зохицуулах газрын дарга, Лхагвасүрэнгийн Энхбат Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Харилцаа холбооны бодлогын хэрэгжилтийн зохицуулах газрын дарга, Дорждэрэмийн Цолмон Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга. Байгаа юм уу. Засгийн хуралтай. Жаргалсайханы Амгалан Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын шинжээч.

Төслийн үзэл баримтлалтай холбогдуулан төсөл санаачлагчаас асуух асуулттай гишүүд нэрээ өгнө үү. Ундрам гишүүнээр тасалъя. Саранчимэг гишүүний микрофоныг нээе.

Б.Саранчимэг: Баярлалаа. Тэгэхээр өнөөдөр бас маш чухал хуулийн төсөл орж ирж байна. Ер нь энэ Монгол Улсад энэ цахим шилжилт хийгдсэнээрээ цахим үйлчилгээ мянга гаруй үйлчилгээг хийдэг болсон байна. Ялангуяа бас энэ и-Монголиа гэсэн энэ платформыг ашигласнаараа бас судалгаагаар 250 тэрбум төгрөгийг бас хэмнэсэн ийм судалгаа байна. Мөн энэ ААН-үүдээ дэмжих хүрээнд энэ и-бизнес платформыг бас нэвтрүүлсэн. Энэ бол бас цаг үеэ олсон, цаг хэмнэсэн хүнд

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 07-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

суртлыг байхгүй болгоход маш том хувь нэмрээ оруулсан ажлууд болж байна. Тэгэхээр энэ цаг хугацаанд бас Цахим хөгжлийн яам мөн энэ Цахим инновацын байнгын хороо уялдаа холбоотой ажиллаж, үнэхээр санаачилгатай ажиллаж, сайн ажиллаж байгааг бас онцлон хэлэхийг хүсэж байна. Тэгэхээр энэ нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг бол дэмжиж байгаа.

Хуулийн төслүүдээс бас зарим нь тодруулах зүйл байгаа. Тэгэхээр төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотой энэ 120 гаруй хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар ингэж орж ирж байгаа. Тэгэхээр ингэж хийгдсэнээр энэ цахим шилжилтийг бүрэн хийх боломжтой юу? Энэ цахим шилжилт төрийн байгууллагуудын хэмжээнд хийгдэх үү? Ер нь бол би энэ төрийн байгууллагуудад дандаа их цаасаар хүмүүсээс юм асуудаг байсан бол одоо тэр өөрт байгаа мэдээллээ иргэдээс дахиж лавлахгүйгээр үүнийгээ ашиглах бүрэн боломж нээгдэж байгаа гэж ойлгож байгаа. Ер нь бол энэ Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд оруулж байгаа нэмэлтээр бол энэ цахим албан хэрэг хөтлөлтийн систем боловсруулах гэсэн байна. Тэгэхээр энэ цахим системийг бүх төрлийн байгууллагуудад нэвтрүүлэх үү. Энэ систем хэзээ бэлэн болох вэ. Хэзээнээс ашиглах боломжтой байгаа вэ гэсэн нэг ийм асуулт байна.

Дараагийн асуудал бол энэ цахим баримт бичиг хадгалах хугацаа нь энэ цаасан баримт бичиг хадгалах хугацаанаас багагүй гэсэн байгаа тийм ээ. Тэгэхээр цахим баримт бичгийг цахим системдээ архивлаад явна гэсэн үг үү? Одоо энэ цахим баримт бичгийг архивлах талаар ийм зохицуулалтууд бас тусгагдсан байгаа юу? Энэ танилцуулгад бол энэ цахим баримт бичгийн хүчинтэй байдлыг хүлээн зөвшөөрөх, нотлох, баримтын хэмжээнд үнэлдэг байх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор хуулийн төслүүдийг боловсруулсан гэж байна. Тэгэхээр нотлох баримтын хэмжээнд

гэдгийг илүү бас тодорхой тайлбарлаж өгнө үү?

Мөн шүүх ажиллагааны хүрээнд нотлох баримт болох уу. Эсвэл шүүхээс бусад тохиолдолд нотлох баримт болох уу. Жишээ нь энэ тэтгэвэр, тэтгэмж тогтооход баримт бичгүүд бүрдүүлдэг. Тэгэхээр энэ тохиолдолд баримт бичгүүд маань нотлох баримтын хэмжээнд тооцогдож чадах уу гэсэн ийм асуултууд байна. Баярлалаа.

Э.Батшугар: Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Цахим хөгжлийг дэмжих багц хуулиудыг баталсан. Тэгээд Нийтийн мэдээллийн ил тод байдлын хууль дээр цахим баримт бичиг нь цаасан баримт бичигтэй адилхан эрх зүйн хүчин төгөлдөр үйлчилнэ гэж заасан ч гэсэн бусад хуулиуд дээр болохоор хэрвээ цахим цаас нь зөрчих юм бол цаасан баримт бичгээ баримтална гэхээр зайлиггүй нөгөө байгууллагууд чинь цахимаар бичгээ солилцож байгаа ч гэсэн хэвлээд хадгалдаг энэ байдал давтагдаад байхаар нэг ажлыг 2 л хийгээд байна гэсэн үг.

Тэгээд сая Саранчимэг гишүүний үг дээр гарч байгаа энэ мэдээллийн сангуудын зөрөөтэй байдал их байгаа. Жишээ нь Жолоочийн даатгалын, Зөвшөөрлийн нэгдсэн сан, Газрын мэдээллийн сан зэрэг энэ сангууд төрийн мэдээлэл солилцооны системтэй холбогдохгүй яваад байгаа. Тэгээд бид нар энэ хуулийн хүрээнд нэг нийтийн мэдээлэл солилцооны системтэйгээ эдгээр мэдээллийн сангуудыг холбож өгч байгаа. Нэг ёсондоо интеграцийг хангаж өгөх эрх зүйн боломжийг нь нээж өгч байгаа. Нөгөө хүүхдийн мөнгө дээр гарсан асуудал ч гэсэн үүнээс л болсон шүү дээ. Мэдээллийн сангууд нь зөрдөг.

2-т, цахим баримт бичгийн албан ёсны хүчинтэй байдлыг цаасан баримт бичгийн нэгэн адил хүлээн зөвшөөрөөд хуульд заасны дагуу стандартаар тогтоосон баримт бичгийн бүрдлээр

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 07-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

баталгаажсан тохиолдолд баримт бичгийн эх хувь гэж үзнэ гээд энэ дагалдах хуулиудаар нь зохицуулж өгч байгаа. Тэгэхээр цахим баримт бичиг бол нөгөө хууль ёсны хүчин чадалтай байгаа гэдгийг нь давхар хуульчлаад өгчихөөр түүнийг нь хэвлээд байх шаардлагагүй болно.

Мөн Зөвшөөрлийн хуультай холбогдуулаад зөвшөөрөл 360-д хүрсэн, багасгасан. Тэгээд и-бизнес гээд платформ нээгээд 270 зөвшөөрлийг компани байгууллага нөгөө лиценз авах, сунгах бүх үйл ажиллагаа цахимжаад ирсэн чинь цахимаар зөвшөөрлөө аваад байдаг. Гэтэл нөгөө зөвшөөрлийнхөө хуудсыг заавал бичгээр хэвлээд ингээд үнэт цаас маягаар хадгалах шаардлага нь нөгөө хуулиараа шаардаад байдаг. Тэгэхээр нөгөө и-бизнесийг амилуулахын тулд бид нар тусгай зөвшөөрөл, энгийн зөвшөөрөл сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох бүх нөхцөлүүдийг нь Зөвшөөрлийн хуулийн практикт хэрэглэх зорилгоор цахим хэлбэртэй байх боломжийг нээчхээж байгаа юм. Үүний хүрээнд и-бизнесээр нөгөө зөвшөөрөл авч байгаа байгууллагууд бол иргэн ч байна уу, шууд зөвшөөрлөө аваад л үйл ажиллагаа явуулах бололцоо эндээс нээгдэж байгаагаараа бас давуу талтай.

Дээрээс нь зарим төрлийн гэрээг цахим хэлбэрээр байгуулах боломжийг Иргэний хуультай нийцүүлээд, ялангуяа жишээ нь Патентын хуулиар шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загварыг ашиглуулах гэрээ, хөдлөх эд хөрөнгийн гэрээ Хөдөлмөрийн тухай хуульд заасан хөдөлмөрийн гэрээ, хөрөнгийн үнэлгээний гэрээ, Өмгөөллийн хуульд заасан хууль зүйн мэргэжлийн туслалцаа авах гэрээ, Аудитын хуульд заасан аудитын үйлчилгээ үзүүлэх гэрээ гээд бас нэлээд олон гэрээнүүдийг цахимаар байгуулах нөхцөлийг бүрдүүлж байгаа. Тэгээд тоон гарын үсгээ унцуулаад л цахимаар гэрээ байгуулж байна. Тэгэхгүй одоо болохоор нөгөө дагалдах хуулиудаар тэр гэрээг заавал бичгээр байгуулна гэхээр цахимаар

байгуулсан ч гэсэн хэвлээд л, хадгалаад л, давхардуулаад л ингээд л давхар энэ цахимжилт чинь өөрөө бүр илүү хүнд суртал, нөгөө төрийн байгууллагууд ч байж иргэддээ ч хүргээд байгаа учраас энэ гацаанаас гаръя гэдэг зорилгоор бид нар бас энэ хуулиудад өөрчлөлт оруулж байгаа.

Тэгээд цаашидаа бол таны хэлж байгаагаар бид нар энэ цахим баримт бичгийн хүчин төгөлдөр байх боломжийг нь салбарын тэр органик хуулиуд дээр нь хийгээд өгчхөж байгаа учраас цахим баримт бичиг бол эрх зүйн хүчин төгөлдөр акт болоод цаашидаа нотлох баримтын хэмжээнд үнэлэгдэх ч гэсэн ийм боломж гарна гэж хэлмээр байна.

Э.Батшугар: Ганибал гишүүн 12 дугаар тойргоос ирсэн байна.

Идэрбат гишүүний микрофоныг нээе.

Ц.Идэрбат: Байнгын хорооны гишүүд өглөөний мэнд хүргэе. Ер нь энэ цахим болно гэдэг бол өөрөө 2 их том зүйл байгаа юм байна л даа. Ер нь бол мэдээллийг ил тод болгоно гэдэг өөрөө бас энэ албан тушаалын гэмт хэрэг гарах, гарсныг илрүүлэх энэ л гол хүчин зүйлүүдийн нэг болдог. Ийм зүйлийг бол манай энэ цахим яамныхан бол бас нэлээн сайн гаргаж ирж ингэж байгаад бас их баяртай байгаа.

Өнгөрсөн чуулганы хуралдаанаар Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль гэж ингэж гаргасан. Энэ дээр төрийн байгууллагууд холбогдох шийдвэрээ байршуулахгүй байх, удаан хойрго байх ийм зүйлийг бас Байнгын хороон дээр бас танилцуулагдаж байсан. Энэ ер нь ямар түвшинд явж байгаа вэ гэдгийг 1 дүгээрт.

2 дугаарт, энэ Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжээд ингээд төрийн тодорхой албан тушаалтнуудын гаргасан шийдвэрүүд ил

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 07-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

болгоход бид сошиал, энэ платформ, энэ сүлжээг ашигладаг шиг тийм энгийн хэрэглээ рүү иргэдэд яаж хүргэх вэ? Гаргасан шийдвэрийг дурын хүн ороод харчих ийм бололцоог хэзээ бас нээх вэ?

2 дугаарт, бас энэ арилжааны банкууд, энэ и-Монголиа-ийн үнэт цаасаар хэвлэсэн тэр тодорхойлолтуудыг ашиглахгүй байх, хүлээн зөвшөөрөхгүй байх, энэ талаар бас иргэдэд нэлээн хүндрэл учирч байгаа ийм зүйлүүд бас яригдаж байсан. Нотариатын асуудал бас байгаа. Энэ болгон энэ зүйлүүд бас л бас нэлээн нааштай шийдэгдэх ийм зүйлүүд бас яригдаж байсан. Энэ дээр би бас сайдын юуг авъя гэж ингэж бодож байгаа юм.

3 дугаарт нь, төв суурин газрууд бол 4 жи гээд сүүлийн үеийн технологиуд нэвтэрчихсэн ингээд явж байна. Ард нь малчид үлдээд байгаа. Тэгэхдээ бол Харилцаа холбооны яамнаас энэ малчид руу хандсан үүргийн сангийн зөвлөлийг бас нэлээн сайн хийж байгаа. Хэнтий аймагт бол 3 газар тендер юм нь зарлагдаад явж байгаа гэж ингэж би ойлгож байгаа. Энэ явц ер нь ямархуу байгаа бол? Бид энэ цахим шилжилтийг бас улс орон даяар нэвтрүүлэхэд энэ малчдын асуудал бас нэлээн чухал байгаа юм.

Өчигдөр Монгол Улсын Ерөнхий сайд “SpaceX” компанийн гүйцэтгэх захирал Илон Масктай бас уулзсан ийм мэдээллүүд бас явж эхэлсэн. Энэ дээрээс тэр одоо үүрэн холбооны сүлжээг газар нутгийн алслагдсан байдлаас хамаарахгүйгээр нэвтрүүлэх ийм технологийн дэвшил бас нэвтэрч эхэлж байгаа юм байна лээ. Энэ тал дээр ер нь Монгол Улс ямархуу байр суурьтай байгаа вэ гэдгийг асуугаад сүүлд нь бол энэ цахим шилжээд цахим, цаасан гээд 2 хэлбэрээр явж байгаа. Цаасан архив бол Монгол Улсын түүхэнд бараг зуугаад жилийн түүхтэй, ямар ч байсан бол бас ингээд явж байгаа.

Одоо цахим архивын асуудал, тэдний аюулгүй байдлын асуудал гэдэг ийм зүйлүүд бас яригдах ёстой байх. Тэгэхээр үүний нөхцөл байдал ер нь ямархуу байдалтай байдаг юм бол гэсэн ийм үндсэн 4 асуултыг бас тодруулъя.

Э.Батшугар: Эхлээд Ганибал гишүүний нэрийг асуулт асуух гишүүдийн тоонд оруулъя.

Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Монгол Улсын Их Хурлаас баталсан энэ Нийтийн мэдээллийн ил тод байдлын хууль дээр мэдээлэл авах эрхийг хангуулах чиглэлээр 68 нэр төрлийн мэдээллийг олон нийтэд нээлттэй болгох үүргийг мэдээлэл хариуцагч нарт оногдуулсан. Тэгээд энэ хуулийг эрчимжүүлэх чиглэлээр Засгийн газраас тодорхой бодлого гаргаад энэ 5Ш ажиллагааны хүрээнд шилэн ажиллагаа дээр тухайлсан албан даалгавар өгсөн. Үүнтэй холбогдуулаад 3 сар хүрэхгүй хугацаанд shilen.gov.mn цахим систем дээр 750 мянга гаруй мөр, өгөгдөл нээлттэй боллоо. Олон нийтийн анхааралд байгаа Засгийн газрын хуулиар нээлттэй болох боломжтой 21 сан нээлттэй болсон. Ингээд төр бол маш их мэдээллүүдийг мэдээлэл хариуцагч нараас аваад олон нийтэд ил болгож байгаа. Үүний цаана бид нар мэдээллийн сангуудын зөрөөтэй байдлыг арилгах зайлшгүй шаардлага байдаг. Ялангуяа тусгай сангуудтай холбоотой архив нь устсан, устаагүй гээд нийгэмд хэл ам дагуулсан, яг цахимаар архивласан баримт бичиг бол устах боломж бол тэр бүр байхгүй шүү дээ. Тийм учраас бид нар мэдээллийн сангуудын нэгтгэх ойлголтыг энэ 120 хуулийг дагуулаад нийтийн мэдээллийн системтэй, газрын мэдээлэл ч нэхдэг, зөвшөөрлийн мэдээллээ ч нэхдэг, бусад тэр жолоочийн даатгалын мэдээллээ ч нэхдэг гээд ингээд хуулиар үүрэг болгож байгаа. Жишээ нь, энэ юутай нэгдэх гээд байна вэ гэхээр нөгөө манай Хур систем. Хур систем бол хуулиараа нийтийн мэдээлэл солилцооны

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 07-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

систем. Одоо хураас 125 төрийн байгууллага, 308 хувийн байгууллага мэдээлэл солилцож байгаа. Нийт сервисийн тоо бол 630-д хүрсэн байхгүй юу. Тэгэхээр энэ бол бас дэвшил. Тэгэхээр бид нар хур-тай төрийн бүх мэдээллийг солилцох боломжийг нь л хангачих юм бол дахиж тэр мэдээлэл алдагдах, иргэний мэдээ мэдээлэлд аюулгүй байдалд нь заналхийлэх, халдлага өртөх, цаашилаад аюулгүй байдал талаасаа ч гэсэн энэ мэдээлэл солилцооны систем ажилласнаараа маш их дэвшил гараад дээрээс нь хоорондоо зөрөхгүй байдал бол дэвшилд хүргэнэ ээ гэж ингэж ойлгож байгаа.

Тийм учраас энэ бас их чухал үр дүн энэ хуулийг дагалдуулж өгнө. Нэг ёсондоо бол и-Монголиа-ийн 970 үйлчилгээ, и-бизнесээр олгож байгаа 270 зөвшөөрлийг шууд цахимаар явуулах нөхцөлийг хууль, эрх зүйн түгжээнээс нь л гаргаж байгаа. Яг нөгөө төрийн байгууллагууд ажил хийх гэхээр, цахимаар авчихсан байна наад өргөдөл гомдлыг чинь бид нар бичгээр л авах ёстой шүү дээ. Яагаад гэхээр өргөдөл, гомдол шийдвэрлэх эрх зүйн орчин чинь энэ шүү дээ гээд л нэхээд байдаг.

Эрүүл мэндийн салбар ч гэсэн бүхэлдээ л ерөөсөө л цахимаар үйл ажиллагаа явуулж болоод байгаа. Гэтэл хуульд нь бичгээр гээд заачихсан юм чинь гээд байдаг. Нөгөө банкны салбар ч гэсэн бүтэн цахимжчихсан. Гэтэл өөрийн биеэр ирээд дансаа нээгээд хуульд нь цагаан дээр араар биччихсэн юм чинь үүнийг өөрчлөхгүйгээр бид нар яаж хууль зөрчих юм бэ гээд байдаг. Систем болоод байдаг, технологи болоод байдаг хууль асуудал байна гээд ингээд байдаг. Үүний дараа бид нар бараг 800 гаруй тушаал, шийдвэр, иргэдийн хурлын тогтоолуудыг өөрчлөх юм байна лээ. Энэ хуулийг. Тэгж байж энэ цахимжилт илүү хурдацтайгаар явахгүй бол цахимжилт нэрийн доор давхар 2 ажил хийгээд байхаар цахимжилт чинь бүр их хүнд суртал руу аваачаад байх вий гэдэг ийм

болгоомжлол байгаа юм. Тэгэхээр Идэрбат гишүүнд бас ийм мэдээлэл өгье.

2-т, тэр бүх нийтийн үүргийн сангаар хэрэгжиж байгаа төслүүд хэрэгжиж байгаа. Хэнтий аймгийн хувьд бид нар бол дандаа хувийн хэвшлийн түншлэлээр зохион байгуулдаг. Жишээ нь, Жи Мобайл компани бол бүх сумуудыг 4 жи-д холбох ажлыг Хэнтийд зохион байгуулж байгаа. Бусад аймгууд ч гэсэн бид нар бол хувийн хэвшилтэй нэгдээд ярилцаад явж байна.

Монгол Улсын Ерөнхий сайд өчигдөр Илон Масктай харилцан бас төслүүдээ танилцуулж нэлээн бас шийдлүүдийн талаар ярилцсан. Өнөөдөр энэ Засгийн газрын хурал... /минут дуусав/

Э.Батшугар: Учрал сайдад нэмэлт 1 минут.

Н.Учрал: Ерөнхий сайдын энэ уулзалтын талаарх Засгийн газар дээр өнөөдөр мэдээллийг сонссон. Үүний хүрээнд бид нар Старлинг компанитай өнгөрсөн 3 сарын хугацаанд Мобайл Ворлд Конгрессын үеэс авхуулаад уулзалтууд хийсэн. Одоо Старлинг дээр компани Монголын Старлинг Монголиа гэдэг компани дээрээ зохицуулах хороонд зөвшөөрлөө хүсээд ингээд үйлчилгээ авах, явуулах эрхээ авах бололцоотой болж байгаа. Зөвшөөрлийн хууль дээр нэг заалтыг хөндөх чиглэлийг бол өгсөн учраас Зөвшөөрлийн хуулийг өргөн бариад ингээд Старлинг Монголд хэрвээ орж ирээд үйл ажиллагаа явуулчих юм бол малчид манай өргөн уудам газар нутагтаа хаанаа ч гэсэн интернэтэд холбогдох ийм бололцоо бас үүсэж байгаа.

Кибер аюулгүй байдал дээр бид нар зөвлөлөө, нийтлэг журмаа, хууль дагуулсан журмуудыг өнөөдөр сүүлийн байдлаар дууслаа. Одоо бид нар Кибер аюулгүй байдлын зөвлөлийг хуралдуулаад нийтийн төв байгуулж, аюулгүй байдлыг хангана.

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 07-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Э.Батиугар: Ундрам гишүүний микрофоныг нээе.

Ч.Ундрам: Манай энэ Цахим хөгжил, харилцаа холбооны яам байгуулагдсан цагаасаа хойш нэлээд эрчимтэй, олон талт ажиллагааг хурдтай ингэж хийж хэрэгжүүлж байгаа. Энэ нь яг олон түмний нүдэн дээр ч гэсэн ил байгаа. Жишээлбэл, И-Монголиа-ийн хэрэглээ маш өндөр хувьтай явж байна. Тэгээд энэ Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу 21 сангийн мэдээлэл ил тод болсон байна.

Мөн газрын мэдээлэлтэй холбоотой мэдээллүүд ил тод нээлттэй болсон байна. Тэгээд энэ 1 асуулт нь болохоор энэ газрын мэдээллийн сантай холбоотой мэдээлэл нь бас яг нарийн судалъя гэхээр энэ Улаанбаатар Зайсангийн газрууд, сургуулийн газрууд маш ихээр алдагдсан гээд салбарын сайд хүртэл ярьж байна шүү дээ. Тэгэхээр энэ газрууд яг хэний эзэмшилд яаж оччихов гэдэг энэ мэдээллүүд төдийлөн тодорхойгүй байна гэсэн ийм зүйл ярьж байна. Тэгэхээр энэ дээр өшөө энэ газрын мэдээллийн сангийн мэдээллийг илүү ард иргэдэд ойлгомжтой нээлттэй болгох уу, цаашилаад гэдэг 1 асуулт байна.

2 дугаарт, энэ төрийн өмчийн, орон нутгийн өмчийн, бас энэ хүүхдийн амралтын газрууд, зуслангуудыг бас хууль бусаар хувьчилсан. Мэдээлэлд ойр хүмүүс тэрийг нь хувьчилж авсан гэсэн ийм зүйлүүд нэлээдгүй яригдаж байна. Улаанбаатар хотоос авхуулаад л хөдөө орон нутагт, манай Сэлэнгэ аймагт гэхэд л 3, 4 хүүхдийн зусланг мэдээлэлд ойр хүмүүс авсан гэсэн ийм иргэдийн гомдол, саналууд ирж байна. Тэгэхээр энэ дээр би бас үүнтэй холбоотой мэдээллүүд ил болох уу гэдэг ийм асуултыг Учрал сайдаас иргэдийнхээ өмнөөс асуумаар байна.

Үүнээс гадна энэ боловсролын салбарт бас архивын асуудал маш ихээр

хөндөгддөг. Тэр олон сургууль, их сургуульд сурч байгаа хүүхдүүдийн дүн, журналаас авхуулаад л маш олон шалгалтын бичиг баримт гээд маш их цаас хадгалагддаг. Тэгэхээр энэ боловсролын салбарт энэ орж ирсэн хуулиуд дунд Боловсролын хууль харагдахгүй байна л даа. Энэ байгаа юу, үгүй юү гэдгийг асуумаар байна.

Ер нь тэгээд манай боловсролын салбар чинь маш их хэмжээний диплом тийм ээ, хувийн хэрэг гэх мэтчилэн олон бичиг баримтуудыг хүүхдүүдэд олгодог. Цаашид ер нь бид нар бүх энэ бичиг баримтуудыг нь илүү бар кодтой, таних тэмдгээр нь иүүд мэдчихдэг, заавал тамга дараад байх шаардлагагүй яг энэ олон улсын стандартын дагуу олгодог болчихвол их зүгээр байгаа юм.

Сая бас энэ гишүүд асууж байна. Цахим кибер аюулгүй байдлын асуудал. Тэгэхээр энэ кибер аюулгүй байдлыг хангах тоног төхөөрөмж, нөхцөл, боловсон хүчин нь ер нь манайд бэлэн байдаг юм уу гэсэн бас нэг асуулт гарч ирж байна.

Э.Батиугар: Доржханд гишүүн ирсэн байна. Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Shilen.gov.mn энэ систем ажиллаж эхэлснээс хойш бид нар бол мэдээлэл хариуцагч нараас мэдээллээ илгээхийг шаардсан. Ерөнхий сайдын хугацаатай албан даалгавар гарсан. Нийтийн мэдээллийн ил тод байдлын хуулийг дагуулаад гарах ёстой нөгөө үнэлгээ хийх орон тооны бус зөвлөл, дээрээс нь мэдээллийг боловсруулж өгөхөд шаардлага тавигддаг нийтлэг шалгуур, шаардлага мэдээллийн бүрэн бүтэн байдал хүртээмжтэй байдлыг хангадаг журмыг бол Засгийн газраас баталсан. Тэгэхээр мэдээлэл хариуцагч нар бол мэдээллийг ил болгосон гэдгээ юу гэж тайлбарладаг вэ гэхээр нэг эксел дээр нэг хэдэн лист тавьчихаад, түүнийгээ нэг сайт дээрээ тавиад тэрийгээ хэн ч ойлгохгүй нэг тийм мэдээлэл тавьчихдаг.

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 07-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Тэгээд түүнийг нь хэн ч ойлгодоггүй. Ингээд газар дээр гэхэд жишээ нь бид бол Нийслэлийн Засаг даргын үе үеийн 20 жилийн, үе үеийн Засаг дарга нарын газар олголтыг эхлээд шаардаад шилэн дээр байршуулсан. Тэгээд байршуулахдаа инфографик хэлбэртэйгээр хайлт хийх боломжтойгоор байршуулсан. Үүний дараа яг тэр нөгөө зуслангийн газар ч байдаг юм уу, нийтийн эзэмшлийн зам талбай дээр газар олгогдохсон мэдээлэл энэ дээр гарч ирэхгүй байна гэсэн. Тэгэхээр тэр нь юу вэ гэхээр нөгөө дүүргийн Засаг дарга нарыг чинь бас тусдаа газар олгогдохсон байгаа шүү дээ. Тэгэхээр дүүргийн Засаг дарга нарын газар олголтыг нийслэлийн газар олголттой холбох ёстой. Ингээд 20 жилийн үе үеийн дүүргийн Засаг дарга нарын газар олголтыг дахиж нэгтгэсэн.

Үүний дараа нөгөө Газар зүй, геодези зураг зүйн газар гэж нэг газар байгаа. Тэгээд Газар зүй, геодези зураг зүйн газар дээр нөгөө аймгийн Засаг дарга нарын, сумын дарга нарын газар олголтын мэдээллүүд, тэгээд энэ бүх газар олголтыг 20 жилээр нь хооронд нь интеграц хийгээд, инфографик хэлбэртэйгээр байршуулсан. Тэгэхээр тэр газар хэн гэдэг хүн тэр газрыг олгосон юм, хэдэн онд, дээрээс нь ангилал нь юу юм бэ гэхээр тэр газрын зориулалтыг нь өөрчилсөн юм уу, эсвэл шинээр олгосон юм уу гэдгийг нь ангиллаар нь харах бололцоотой. Тэр Shilen.gov.mn-ээр ороход ангиллууд нь байгаа. Үе үеийн хэн гэдэг дүүргийн Засаг дарга, хэн гэдэг Нийслэлийн Засаг дарга, эсвэл тусгай хамгаалалттай газар байвал хэн гэдэг Байгаль орчны сайд олгосон юм бэ гэдгийг нь дээр нь анализ хийх боломжтой. Тэгээд одоо авсан хүн нь ч тодорхой байгаа, олгосон хүн ч тодорхой байгаа. Магадгүй газрыг захирамжаар авчхаад бусдад 3, 4 дамлагдаад ингээд зарагдчихсан байгаа тохиолдлыг ч гэсэн харах боломжтой. Эрх нь хэдэн удаа сунгагдсан бэ. Хэрвээ өөр хүнд зарагдсан байгаа тохиолдолд нөгөө нэг Засаг дарга чинь захирамжаараа нөгөө эрхийг нь

шилжүүлж байгаа шүү дээ, өөр хүнд. Тэгээд ингээд хэд хэд ингээд солигдчихсон байгаа гэсэн үг. Тэгээд үүнийг хянах бололцоо байгаа учраас хэн нэгнийг онцгойлоод энэ нь буруу шийдвэр байсан, зөв шийдвэр байсан гэж би бол өөрөө Засгийн газрын гишүүний хувиар тэгж шүгэл үлээх нь тийм ёс зүйтэй асуудал биш. Үүнийг бол иргэд олон нийт дата дээрээ нээлттэй мэдээлэл дээрээ анализ хийх нь бол өөрсдийнх нь эрх ээ гэж хэлмээр байна.

Боловсролын хуультай холбогдуулаад бид энэ 120 хуульд хөндөхөөс илүү Боловсролын ерөнхий хууль дээр нөгөө цахимын бүлэг орсон байгаа шүү дээ. Тэгээд тэр асуудлаар өөрснөө шийдээд явж байгаа.

2-т, боловсролын салбар харьцангуй бол сайн цахимжиж байна. Жишээ нь Боловсролын сайд нөгөө дипломыг блокчэйн дээр бүртгээд, нөгөө хуурамч дипломын асуудлаас салж байгаа юм. Үүн шиг бид нар и-Монголиа дээр бүх лавлагааг үнэ төлбөргүй болгосон шиг лавлагааг блокчэйн дээр бүртгэж эхлэх гэж байна. Блокчэйн дээр бүртгээд эхэлчихээр нотариатын үйл ажиллагаа бол нөгөө лавлагааг тамгалдаг байдал үгүй болно. Харин одоо бол и-Монгол дээр та нотариаттай гэрээ байгуулсан бол нотариатын бүх гэрээ ордог болчихсон. Ингээд нотариатын гэрээг лавлагаа и-Монголиа мн гэдэг шиг системээс төрийн байгууллага өөрөө хардаг болчихсон буюу иргэнээсээ цаас нэхэхгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн.

Кибер аюулгүй байдал ч бай, аймгийн мэргэжилтнүүд ч бай, мэргэжилтний хомсдол бол манай салбарт маш их байгаа. Тийм учраас цалингийн хувьд ч гэсэн, итгэлцүүрийн хувьд ч гэсэн өөрөөр тогтоож авч үзэхгүй бол ер нь манай салбарт бол хүн олдох бол маш хэцүү болсон шүү дээ.

Э.Батшугар: Ганибал гишүүний микрофоныг нээе.

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 07-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Н.Ганибал: Энэ хуулийг яаралтай батлаад цааши нь хэрэгжүүлэх шаардлагатай л даа. Мэдээж яг олон давхардлууд, олон нөгөө шилжилтийн энэ яг цаг хугацаан дээр энэ системийн бүрэн энэ шинжилгээнийхээ үр дүнг л өнөөдөр бид нар хуульчлаад нэгдсэн байдал руу оруулах гэж байгаа гэж ойлгож байгаа. Одоо яг нэг ийм нэг Сонгуулийн тухай хууль хэлэлцэж байгаа энэ цаг хугацаан дээр нэг хэд хэдэн асуудлууд байгаа юм. Цахимжуулах асуудлууд. Энэ дээр ер нь манай яамныхан ямар бодолтой байна? Нэгд нь Үндэсний бүртгэлийн дата системийг Монгол Улсын бүх өнцөг булан бүрд нэг өдөр ингээд хэрэгжүүлэх энэ боломж юу байна вэ? Яагаад гэхээр ингээд холимог системтэй болчихсон. Холимог систем гэдэг бол Монгол Улсын иргэн сонгогч нэг л тэр намын төлөө саналаа өгнө, тийм ээ. Тэрийг 2 өгөх боломжийг хаасан онлайн тийм платформ бид нарт зайлшгүй хэрэгтэй байгаа юм. Үүнийг шийдэх ямар боломж байна?

Мэдээж гарах хүндрэлүүд нь бол хол зайдуу газар, бөглүү газар нөгөө сүлжээ байхгүйгээс болоод санал авах байр дээр тухайн программ ажиллахгүй, онлайн ажиллахгүй байх харагдаж байгаа. Хэрвээ старлинг орж ирээд боломж нь нээгдвэл мэдээж болох байх. Цаашилаад хэрвээ старлингийн үйлчилгээ авахаас үйлчилгээг нэвтрэхээс өмнө бас үүнийг яаж болох вэ? Ер нь бол зүгээр найр наадам дээр бол нэг явуулын сүлжээ ажиллуулаад болоод байдаг байхгүй юу. Монгол Улсын хэмжээнд миний бодсоноор бараг 50-аас дээш хувь багууд бол багийн төвүүд буюу санал авах байрууд бол сүлжээнд холбогдох ийм боломжсоор хангагдсан байгаа. Тэгэхээр энэ дээр та бүхэн маань ямар бодол байна?

2-т нь, тэр үндэсний тэр дата юуг, программыг өнөөдрийн байгааг нь сайжруулаад ажиллуулах ямар боломж тэр талын судалгаанууд байна уу? Ер нь нэг яригдаад байгаа гол юм нь Сонгуулийн

тухай хуульд дэвшилтэт юм бол нөгөө сурталчилгааны самбаруудыг нэгдсэн байдлаар хийх. Түүн дээр бол плакат юмнуудаа наана гээд ингээд явж байгаа юм. Түүнтэй яг адилхан бид нар бас ингээд 20 оны сурталчилгаанд сонгуульд нэр дэвшигч нар фейсбүүктээ бид нар 20 орчим сая долларыг зарсан юм байна лээ. Бүүст хийх мэдээллээ тавиад одоо бүүстний л үнэ шүү дээ, тийм ээ. Энэ 20 сая доллар бид нар тэр Монгол Улсаас зүгээр паг гээд л гараад явчихдаг. Ямар нэгэн татвар төлөөс энэ эргэж тэнд ямар нэгэн хяналтаа ч бид нар бүрэн тавьж чаддаггүй. Энэ дээр ер нь бид нар яг нөгөө самбар дээр хүмүүс ижилхэн мэдээллээ тавина гэдэг шиг Монгол залуучууд нэгдсэн сурталчилгааны яг сонгуулийн тийм мэдээлэл дамжуулах Монгол Улсын иргэн болгонд очих боломжтой тийм, арай ч фейсбүүкийг давна ч гэж юу байх вэ. Фейсбүүкийг ч бас хорин ч гэж юу байх вэ, тийм ээ. Ер нь зүгээр энэ мэдээллийг зөв аваачих ийм боломж юу байдаг юм бол гэсэн бас яг энэ Сонгуулийн хуультай холбоотой яах вэ зүгээр ер нь зүгээр дэлхийн бусад улс орнуудад бол фейсбүүкийн салбарыг байгуулаад улсдаа. Тэгээд тэндээсээ бас татвар авдаг. Авсан тохиолдлууд бас байна. Хяналтаа тавьсан тохиолдлууд бас байгаад байгаа юм байна лээ. Энэ талаар ер нь та бүхний судалсан, бодсон юмнууд байна уу гэж асууя.

Э.Батиугар: 3 номерын микрофоныг нээе.

Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын зөвлөх Тэнгис байна.

Ганибал гишүүний асуултад хариулахад сонгуулийг ер нь цахимаар хийх тухай их олон жил бид бид нар ер нь ярьж байгаа. Тэгээд бас нөгөө тодорхой нөхцөл байдал бүрдээгүй, иргэдийн тоон бичиг үсгийн боловсрол, мэдлэг, ойлголт багатай энэ тэр гээд их олон хүчин зүйл байсан. Тэгээд энэ жилээс сонгууль болон тогтолцоо өөрчлөгдөж байгаатай холбоотойгоор сонгуулийг цахимаар

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 07-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

хийж болох тухай бас ойлголт явагдаж байгаа. Ялангуяа нэгдсэн том тойрог буюу пропорциональ элемент, нөгөө тогтолцоо орсон үед бол боломжтой гэж үзэж байгаа. Энэ тал дээр яг энэ сонгуулийн автоматжуулсан систем, сонгуулийн мэдээллийн сүлжээ тэр талын асуудлыг бол нөгөө Сонгуулийн ерөнхий хороо болон бусад Цахим хөгжил, харилцаа холбооны холбооны яам, Зохицуулах хороо, Тагнуулын ерөнхий газар гэсэн тэр нөгөө бүрэлдэхүүн шийдвэрлэж тэндээ шийдэл нь гарч байгаа. Одоо нөгөө яг ид явагдаж байгаа Сонгуулийн хуулийн бас өөрчлөлтийн үр дүнг бас харж байгаа гэсэн мэдээлэлтэй байна.

Фейсбүүкийн хувьд яалт ч үгүй бас сонгууль болгоноор бас маш их хэмжээний мөнгөн урсгал гадагшаа гардаг, 20 сая доллароос ч их мөнгө гарсан тооцоо байдаг. Энэ талаар бас Монгол Улсын Засгийн газар, Цахим хөгжил, харилцаа холбооны яам бас фэйсбүүкийн холбогдох түнш байгууллагуудыг Монголд байгуулах талаас нь бас хамтарч ажиллаад бас үр дүнгээ өгч эхэлж байгаа юм. Жишээ нь дурдах юм бол фэйсбүүкийн арилжааны түнш Интра гэж Монгол дахь төлөөлөгчийг 2023 оны 1 дүгээр сараас эхэлж үйл ажиллагаагаа ажиллаж эхэлсэн. Өөрөөр хэлбэл энэ түнш Монголд байгуулагдсанаар яах вэ гэхээр фэйсбүүкээр дамжиж реклам сурталчилгаа бүүст хийх байгууллагууд Монгол дахь төлөөлөгчийн газар Монгол компанитай нь гэрээ байгуулаад, Монгол мөнгөөр төлбөрөө төлөөд, тэнд аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татвар бүх татвар хураамж нь бол Монгол Улсад үлдэх тийм боломжтой болчихсон. Одоо аль хэдийн үйл ажиллагаа нь өргөжөөд явж байгаа.

2 дугаарт, фэйсбүүкийн бас тухайн улс орныхоо сонгууль болон тийм онц чухал үйл явдалд бас их онцгой анхаарал өгч ажилладаг. Тэгээд өмнөх жилүүдэд ч гэсэн фэйсбүүктээ бас ногоон

шугамын цаана ажиллах хүний тоог нэмэгдүүлэх, сонгуулийн нөгөө сурталчилгаа хаасан хугацаа нь хоног нь дууссан үед бас янз бүрийн тийм нөгөө сурталчилгаатай холбоотой юм байх эсэхийг бас тийм харах, хянах тогтолцоог бас бүрдүүлж ажилладаг. Тэгээд энэ жилийн хувьд бас бид нар саяхан 10-аад хоногийн өмнө Цахим хөгжлийн яам бас Фейсбүүкийн Монгол дахь түнш байгууллагатай бас иргэдийн тоон бичиг үсгийн боловсрол болон бусад чиглэлээр хамтран ажиллах тэр санамж бичгийг байгуулаад тэр хүрээндээ бид нар бас сонгуулийн үеэр ирж байгаа сонгуулийн үеэр бас өмнөх жилүүдийн адил тэр хамтын ажиллагаагаа хэвээр нь хадгалж бас идэвхтэй ажиллана гэж бас тэгж тохирцгоосон байгаа.

Э.Батшугар: Нэмж асуух уу, тодруулах уу? Учрал сайдын микрофоныг нээе.

Н.Учрал: Өнгөрсөн хугацаанд манай улс бол 21 аймгийн одоо нэг 4 сум л үлдлээ л дээ. Бүх сумуудыг шилэн кабелиар бол холбосон. Энэ онд бол ингээд 4 сумаа дуусгана гэсэн төлөвлөгөөтэй байгаа. Ингээд цаашилаад бүх багт нөгөө дэд бүтэц байгуулаад ажиллана гэдэг бол зах зээлийн хувьд ч гэсэн боломжгүй. Одоо бол яах вэ, зүгээр нэг холболтууд хийгээд 1226 баг дээр нэг ийм холболт хийгээд, зарим багт очиход нэг утас ажилладаг ч юм уу, нэг ийм харилцаа. Түүнээс энэ бол нэг дэд бүтэц байгуулаад, тауэр бариад ингээд интернэт оруулчхаж байгаа юм биш. Тэгэхээр ерөөсөө бид нар нөгөө харилцаа холбооны шинэ дэд бүтэц рүүгээ орохгүй л бол манайх шиг өргөн уудам газар нутагтай улсад бүгдийг нь кабель интернэтэд холбоод, малчдын өвөлжөө болгонд кабель хүргэнэ гэж байхгүй. Тийм учраас шинэ дэд бүтэц эрэлхийлэх нь зөв юм байна гэж үзээд би бол ажил авснаасаа хойш энэ старлинг SpaceX-тэй мобайл ворлд конгрессын үеэр уулзалт хийгээд, заавал газрын станц байгуулна гэдэг ийм шаардлагыг сайдын бодлогын чиглэлд тусгачихсан байхыг нь болиулсан.

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 07-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Яагаад гэхээр тэр лицензтэй, лицензгүй тэр антенныг нь зүгээр нэг ийм тавган антен аваад л малчид ч байна уу, хэн ч байна уу интернэт шууд холбогдож байна шүү дээ. Тэгэхэд бид нар үүнийг зохицуулах боломж бол байхгүй. Тэгэхээр энэ бодлогын чиглэлийг цуцалсан.

Одоо Харилцаа холбооны зохицуулах хороо өчигдөр энэ Илон Масктай Ерөнхий сайд уулзалт хийсний дараа бид нар Зөвшөөрлийн хууль дээр нэг тодорхой өөрчлөлт оруулчих юм бол нөгөө давтамжийн үйлчилгээ явуулах, лицензийн үйлчилгээ явуулах зөвшөөрлийг нь тэр компанид нь өгчих. Тэгээд тэр компани үйл ажиллагаа явуулбал иргэд өөрсдөө малчид ч байна уу, тэр антенаа аваад л интернэтэд орно. Интернэтэд орно гэдэг чинь утас шөрмөс, ай пи тв, телевизороор чөлөөтэй болно гэсэн үг. Мэдээж энэ бол арилжааны шинж чанартай компани. Бид бол нөгөө үндэсний аюулгүй байдлаа хангах үүднээсээ сансрын хиймэл дагуулыг хөөргөх цаг бол нэгэнт ирсэн. Тийм учраас сая Францын Ерөнхийлөгчийн айлчлалын үеэр Монгол Улсын Ерөнхийлөгч бас албан хүсэлтээ тавьсан. Бид нар хамтарч ажиллая гээд. Ингээд Ерөнхийлөгчийн айлчлалын өмнө манай яамны бүрэлдэхүүн тэр Францын Талс Алиана компани дээр Байнгын хорооны дарга бид нар очиж ажиллаад нөхцөл байдалтай танилцсан. Яг энэ өдрүүдэд мэргэжилтнүүд Монголд ажиллаж байна. Ингээд бид нар техникийн хувьд шинэ ТЭЗҮ-ээ боловсруулж байна. Ингээд бид Сансрын үндэсний зөвлөлөөр оруулна. ҮАБЗ-д танилцуулсан. Ингээд ер нь хурдацтайгаар энэ сансрын үндэсний хиймэл дагуулын төслөө урагшлуулчихъя. Энэ бол манайх шиг ийм 2 том хөрштэй оронд бас маш их чухал юм байна. Зүгээр тэр нам орбитын хиймэл дагуул бол тэр чинь ойрын зайнд байгаа. Дээрээс нь заавал нөгөө газрын станцаар дамжиж үйлчилгээ явуулдаггүй, хэрэглэгч шууд холбогдож байгаа учраас хамааралгүйгээр интернэт хүлээж авах ийм бололцоо бүрдүүлнэ.

Тэгэхээр ийм шинэ дэд бүтэц рүү явах цаг ирсэн. Түүнээс биш жил болгон бид нар нэг үүргийн сангаар ч гэдэг юм уу эсвэл хувийн компаниудаасаа хүсэлт тавиад л ингээд л багуудыг холбоод байна гэвэл энэ хэзээ ч үр дүнд хүрэхгүй. Одоо бол манайх нэг газар нутгийнхаа 3-ны 1-д л шилэн кабель орсон байна шүү дээ, 3-ны 1-д л. Тэгэхээр цаашидаа зардал мөнгөний хувьд ч, цаг хугацааны хувьд ч баг болгонд кабель оруулах боломжгүй учраас дэд бүтцийг шинэчлэх ажлуудыг зохион байгуулах тал руугаа л бид хандаж байгаа. Хэрвээ зүгээр нам орбитын хиймэл дагуулын үйлчилгээ Монголд ороод ирвэл тэр таны хэлж байгаа тэр сонгуулийн байруудаар бусад газруудаар ингээд байршуулаад интернэт холбоо харилцаанд нь холбоод явах бололцоо бол үүснэ л дээ.

Э.Батшугар: Ганибал гишүүн 1 минут.

Н.Ганибал: Учрал сайдын яриад байгаа яг л бодитой л байна л даа. Одоо яг амьдрал дээр өнгөрсөн жил Сүхбаатар аймаг нийтдээ нэг 14 хөдөө орон нутгийн алслагдмал багууд дээрээ цамхагтай нөгөө нэг антенууд тавиад ингээд явсан. Тэгээд энэ жил эргээд нөгөө жи юутай. Манайх чинь Юнителтэйгээ эргээд ингээд хэлцэл хийх гээд яасан чинь танай тавьсан антенууд ашиггүй байна аа. Тийм учраас энэ жил бид нар хөрөнгө оруулалт нэг төгрөг ч хөдөөгийн тэр багууд дээр хийхгүй гэдгийг албан ёсоор ТУЗ дээрээ ярьчихсан гээд байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ асуудлууд бол мэдээж арилжааны асуудлууд учраас бид нар дараагийнхаа алхам руу орохгүй бол болохгүй ээ, үйлчилгээ очихгүй юм байна гэдэг л энэ асуудал үүсчхээд байгаа юм. Тэгээд бас тэр бүх нийтийн үүргийн сан дээр байгаа мөнгө бас хангалттай бус байна гэдэг арилжааны юунууд операторууд бас яриад байна лээ. Тэр тал дээрээ ... /минут дуусав/

Э.Батшугар: Учрал сайдын микрофоныг нээе.

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 07-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Н.Учрал: Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан бол энэ өөрөө Харилцаа холбооны зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа байгууллагуудын өөрсдийнх нь бүрдүүлсэн орлогоос нөгөө цэвэр ашигийн дараах татварын 3 хувь байхгүй юу. Тэгээд энэ мөнгө нь бүрдээд тэр санхүүжилтээрээ бүх нийтийн үүргийг хэрэгжүүлэх хүрээнд л сумуудыг холбосон. Одоо бол манай энэ оператор компаниуд хэлж байгаа. Бид нар бол үүргээ биелүүлсэн шүү. Өнгөрсөн хугацаанд бүх сумыг чинь холбоход онцгой хувь нэмрээ оруулсан гэдэг зүйлийг хэлдэг. Тэгэхээр та нар шинэ дэд бүтэц рүү орохгүй бол 200 хүнтэй баг дээр кабель оруулчихна, тэгээд хэн авч явах вэ, урсгал зардлыг хэн хариуцах вэ, ашиггүй учраас хувийн компани орохгүй. Тэгэхээр Монгол Улс шинэ дэд бүтэц рүүгээ орохгүй л бол цаашаа ингээд ерөнхийдөө батарей дуусаж байна л гэсэн үг л юм байна лээ.

Э.Батиугар: Би нэг хэдэн асуулт асууя. Эхний байдлаар бол эхний асуулт нийт өнөөдрийн байдлаар 700 мянган иргэнд цахим гарын үсэг олгосон байгаа. Энэ 700 мянган гарын үсгээс 400 мянга хавьцаа нь бид нарын ашигладаг нөгөө нэг иргэний үнэмлэхийн ийм ви чип дээр суурилчихсан. Тэгэхээр яг энэ цахим үнэмлэхээ ашиглаад цахим гарын үсгээ бүрэн хэрэгжүүлж чадах уу? Болж байна уу? Унидаг төхөөрөмж нь байгаа юу? Хангалттай гадуур, 1 дүгээр асуулт.

2 дугаар асуулт, энэ хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбоотойгоор и-бизнес платформ бүрэн цахимжиж чадаж байгаа юу? Ялангуяа тодруулж асуувал, Монгол Улсын иргэн гэртээ юм уу, оффистой сууж байгаад и-бизнес платформыг ашиглаж компани байгуулж болох уу, аль эсвэл тусгай болон энгийн зөвшөөрлийг цахимаар авч сунгаж болох тийм бололцоог нь нээж байгаа юу гэж асууя.

Түрүүн бас Учрал сайд хэлсэн, энэ нотариатын үйлчилгээг

цахимжуулахтай холбоотойгоор бас дэлгэрэнгүй тайлбарлаж өгөөч. Энэ яаж иргэддээ, иргэнд шууд хүрч байгаа вэ? Энэ өөрчлөлттэй холбоотойгоор. Баярлалаа.

Учрал сайдын микрофоныг нээе.

Н.Учрал: Тоон гарын үсэг 700 мянга гарсан. Тэгэхдээ яг хэрэглэж байна уу гэдэг дээр хяналт тавих л хэрэгтэй. Яг 700 мянган хүн тоон гарын үсэг хэрэглээд байна уу, үгүй юү гэж. Бас их эргэлзээтэй. Зүгээр тараагаад өгчихсөн яг хэрэглэх, хэрэглээнд нь нэвтэрч эхэлдэггүй. Гэтэл 15 онд тоон гарын үсэг тараахад 4 жилийн хугацаанд 30 мянга нь л тоон гарын үсэг тараахад 30 мянгын хэрэглээ бол нөгөө НДШ-ийн тайлан өгөхөд, нөгөө тендерт оролцоход гэдэг ийм 2 зориулалтаар л хэрэглэж байсан, нөгөө хэрэглээг нь хөшүүрэгдээд эхлэхээр.

Тэгэхээр төр бол зайлиггүй тоон гарын үсэг дээр манлайлаад эхлэх ёстой юм байна. Тэгсэн чинь өргөдөл, гомдлуудыг хариуг нь цахимаар явуулах, нөгөө гэрээнүүдийг цахимаар хийх дээр тоон гарын үсэг заавал дарах хэрэгтэй болдог. Тэгэхээр энэ хуулиудыг өөрчилснөөр би энэ тоон гарын үсгийн хэрэглээнд орно гэж бодоод байгаа юм. Яагаад гэхээр нэг гэрээ хийчихлээ тийм ээ. Нотариатын жишээ нь гэрээ хийчихлээ, эсвэл нэг өмгөөллийн хууль зүйн туслалцааны гэрээ хийчихлээ гээд 2 тал тоон гарын үсгээ дараад ингээд явдаг болчих юм бол хүн заавал тэгээд л биеэрээ уулзаад ингээд байхаасаа илүүтэйгээр тоон гарын үсгээ дараад явахаар нөгөө хэрэглээ нь дэмжигдээд эхлэхээр тоон гарын үсэг илүү хэрэгдэнэ. Хүмүүс чинь нөгөө и-тендерт оролцох гэж л тоон гарын үсэг хэрэглэдэг, 30 мянга хүргэсэн байсан шүү дээ.

Тэгэхээр энэ хууль гарснаараа тоон гарын үсгийг би их дэмжинэ гэж ойлгож байгаа. Дээрээс нь яах вэ, төхөөрөмжүүдийн хувьд төр өөрөө энэ төхөөрөмжүүдийг хангалттай байршуулаад дээрээс нь манай энэ Төрийн

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 07-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

цахим үйлчилгээний зохицуулалтын газар бол нөгөө иргэний үнэмлэхийг нь уншигчаа тавиад л тоон гарын үсэг уншуулаад явж байгаа. Зүгээр гар утсан дээр бүртгэлийн байгууллагын гаргасан жи сайн бол и-Монголтой холбогдоод л жи сайн дээрээ тоон гарын үсгээ авчихсан бол и-Монгол бол шууд таниад и-бизнес ч гэсэн шууд таниад явчхаж байгаа учраас энэ бол гар утасны хэрэглээн дээр бол ямар нэгэн асуудал үүсэхгүй байгаа.

Нэг цэгийн үйлчилгээнүүд дээр бол бид нар иргэний үнэмлэхийг нь уншуулж байгаа. Тоон гарын үсгийн гэрчилгээ олгох байгууллагуудад зөвшөөрөл өгөх эрх бол Цахим хөгжлийн яаманд байдаг. Тоон гарын үсгийн гэрчилгээг нөгөө тоон гарын үсгийн үйлчилгээ явуулах клауд дээр тавих үйлчилгээг явуулах эрхийг авах компаниуд төдийлөн байхгүй байгаа. Яагаад гэвэл иргэн болгонд шууд олгох ийм хуультай учраас. Тэгэхээр бид бол хэрэглээг нь дэмжиж байж л тоон гарын үсгээ нэмэгдүүлэх юм байна гэж бодож байна.

И-бизнесийн хувьд бид нэлээд их ажилласан. И-бизнес бол Лайсенс мн гээд Уул уурхайн яамны, Сангийн яамны, Эдийн засгийн яамны зөвшөөрлүүд ингээд байсан. UB онлайн гээд Улаанбаатар хотын бүх зөвшөөрлүүд байсан. Дахиад и-монгол дээр зарим яамнуудын компани, ААН-үүдийн зөвшөөрөл байсан. Эд нар ингээд тал талд ажиллаж байдаг байсан. Эдгээрийг бид нар интеграц хийгээд бүгдийг нь холбоод и-бизнесийг гаргасан. Тэгээд и-бизнес бол иргэнээ бид нар нөгөө дангаар таньж байгаа учраас хурдтайгаа шууд холбогдоод, иргэнээ таниад тоон гарын үсгээ уншуулчих юм бол компанийнхаа нэрийг шүүлгэж байна, компани байгуулж байна, лицензээ сунгаж байна, эрхээ сунгаж байна, зөвшөөрөл авч байна. Ингээд хэрвээ энэ хууль батлагдчих юм бол и-бизнес бүр илүү их амилна гэж би бас бодож байгаа. Тэгээд энэ бол бас онцгой чухал юм байна.

Нотариат дээр бол и-Монгол дээр нотариатын хийгдсэн гэрээнүүд шууд

орчхож байгаа гэсэн үг. И-Монгол дээр иргэн Батаа очлоо, миний би өөрийгөө таниулчихлаа гэхэд дотор нь миний байгуулсан бүх нотариатын гэрээ байж байгаа. Тэр машин шилжүүлэх гэж байгаа 2 тал явж очлоо гэхэд өөрийгөө таниулчих юм бол тэр нотариатын гэрээг нь харилцагчийн таньж мэдсэнийг нь зөвшөөрсний үндсэн дээр тэр АТҮТ-ийн ажилтан түүнийг хараад, нотариатын гэрээг нь хараад нотариатыг нэхэхгүйгээр шууд машинаа шилжүүлчих ийм л болчихсон байхгүй юу. Тэр нотариатын бүх төрлийн гэрээг гартаа барьж явах шаардлагагүй болсон. Үнэхээр нотариаттай гэрээ хийсэн байгаа бол тэр чинь и-монгол дээр орчихсон, хүн татаад үзчихэж болно л гэсэн үг.

Э.Батшугар: Баярлалаа.

Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан гишүүд асуулт асууж, дууслаа.

Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан үг хэлэх гишүүд байна уу, нэрсээ өгнө үү. Чинбүрэн гишүүнээр тасалъя.

Ж.Чинбүрэн: Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе. Чухал зүйл бид хэлэлцэж байна. Ялангуяа энэ төрийн үйлчилгээ цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор олон хуулиудад энэ давхцалыг арилгах, мөн сая ярьж байгаа чухал зүйл бол бид ер нь цахим хэлбэрээр ялангуяа манай эрүүл мэндийн салбарт бол дандаа зөвшөөрөл эмчилгээ болгонд, үйлдэл болгон зөвшөөрөл авдаг. Энэ зөвшөөрлүүд дандаа цахим хэлбэрээр байх боломжтой боловч энэ яг амьдрал дээр хэрэгжихгүй байгаад байгаа гол гацаа, гох дэгээ бол ерөөсөө энэ хуульдаа бид оруулж өгөх ёстой юм. Үүнийг бат баталгаажуулж өгөх ёстой. Үүний гол бас нэг баталгаа нь бол энэ цахим гарын үсэг, тоон гарын үсэг байгаа. Тэгэхээр тоон гарын үсгийн нэмэгдэл хэрэглээг

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 07-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

нэмэх гол бас нэг зогцоо бол бид энэ цахим орчинд энэ гарын үсгийг ашигладаг болох нь өөрөө хэрэглээг нэмэгдүүлэх үүнийг бодитой болгох том алхам болно. Тийм учраас энэ хуулийг хэлэлцэх эсэхийг бол дэмжиж үг хэлж байгаа юм.

Тэгээд энэ олон хуулиудад бичгээр гэснийг цахим болгох тэгээд цахим орчинд илүү орчин цагтайгаа уялдсан энэ өөрчлөлтүүдийг бид хурдан хийх шаардлагатай байгаа учраас Байнгын хороо, гишүүд үүнийг дэмжиж цааш хэлэлцэх асуудлыг нь дэмжээд явах нь зүйтэй гэж бодож байна.

Э.Батшугар: Баярлалаа. Тэгээд миний хувьд ч гэсэн бас энэ хуулийг дэмжиж байгаа юм. Тэгээд Монгол Улсын Засгийн газар цахим үндэстэн болно гэсэн том зорилго тавьсан. Үүний хүрээнд Инновац, цахим бодлогын байнгын хороо Цахим хөгжлийг дэмжих 4 багц хууль батлаад тэгээд 2022 оны 5 сарын 1-нээс эхэлж хэрэгжиж эхэлсэн.

Инновац, цахим бодлогын байнгын хороо бол өнгөрсөн 9 сараас эхлээд нийтдээ жаргаад төр, хувийн хэвшлийн байгууллагуудтай уулзсан. Хуулийн хэрэгжилтийн талаар санал бодлоо санал солилцож. Тэгэхээр 1 асуудал гараад байсан юм. Тэр нь энэ яг өнөөдөр хэлэлцэж байгаа асуудалтай холбоотойгоор Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль дээр төр өөрт байгаа мэдээллийг иргэнээс асуухгүй, нэхэхгүй гэсэн заалт байгаа.

Мөн 2-т нь бол цахим гарын үсэг болон цахим бичиг баримт бол цаасан бичиг баримттай адилхан хэлбэрээр хүчинтэй байна гэж заасан. Харин энэ сайн хэрэгжихгүй байгаа үндсэн санаа нь шалтгаан нь манай салбарын хуулиуд бас зөрөөтэй байсан. Нийцэхгүй байсан. Салбарын хуулиуд дээр заавал бичгээр, заавал биеэр хүрч ирж бичиг баримтаа өгөх ёстой танилцуулах гэж заачихсан байсан. Тэгэхээр энэ 120-оод хуулийн өөрчлөлтүүдийг хийснээр энэ бүх

давхардал арилж байгаа юм. Бичгээр болон цахимаар эсвэл цахимаар гэсэн тийм заалт орж байгаа юм. Тэгэхээр иргэн заавал өөрийн биеэр очихгүй цахимаар тоон гарын үсгээ баталгаажуулсан бичиг баримтаа шууд төрд илгээгээд тэгээд төрийн үйлчилгээгээ шууд авах бололцоо нээгдэж байна.

Мөн тусгай болон энгийн зөвшөөрлийг шууд оффисоосоо илгээгээд эргээд хариу авах бололцоо нээгдэж байгаа. Дээрээс нь нэмээд и-бизнес платформ бол цэвэр бизнес эрхлэгч нарт маш том дэмжлэг болно. Заавал төрийн байгууллагад очиж очерлож үйлчилгээ авахгүйгээр оффисоосоо шууд цахимаар хүсэлтээ илгээгээд тэгээд хариугаа төрөөс шууд цахимаар авах бололцоо нээгдэж байгаа юм.

Ингэснээр маш их хэмжээний цаг хугацаа болон зардал хэмнэж байгаа юм. Үүнийг зориуд дурдаж хэлэхийг бодсон юм.

Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан гишүүд үг хэлж дууслаа.

Санал хураалт явуулъя.

Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, ЭМД-ын тухай хуульд нэмэлт оруулах тухай болон бусад хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

100 хувийн саналаар дэмжигдлээ.

Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 07-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

арилгах зорилгоор Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай тухай, ЭМД-ын тухай хуульд нэмэлт оруулах тухай болон бусад хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх талаар хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

12.08 цаг

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаанаа хаасныг мэдэгдье.

Хүрэлцэн ирсэн гишүүддээ баярлалаа.

Хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Чинбүрэн танилцуулна.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ

12.07 цаг

П.ОЮУНГЭРЭЛ

Дараагийн асуудалдаа оръё. 2 дахь асуудал.

“Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 6 дугаар сард Инновац, цахим бодлогын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглаврыг батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл.

Тогтоолын төслийг та бүхэнд тараасан байгаа.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрээ өгнө үү. Алга байна.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд нэрээ өгье. Байхгүй, алга байна.

“Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 6 дугаар сард Инновац, цахим бодлогын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглаврыг батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Санал 100 хувиар дэмжигдлээ.